**ХЭНТИЙ АЙМГИЙН**
**ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 24 өдөр        Дугаар А/44        Баян-Овоо

Дадалын ухаа үүлдрийн үхэрт үзлэг ангилалт хийж, малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.11, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр 14.2.3, Малын генетик нөөцийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.8.6, 18 дугаар зүйлийн 18.2.2, 18.2.3 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны А/136 тоот тушаал, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2 дугаар хуралдааны "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" О6 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2024 ны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/216 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дадалын ухаа үүлдрийн үхэрт хаврын үзлэг ангилалт хийж, малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэлтэнд хамруулах ажлыг зохион байгуулсугай.

2.Дадалын ухаа үүлдрийн үхрийн генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлон, стандартын шаардлага хангасан үржлийн малыг ялган тэмдэглэж, бүртгэлжүулэх ажлыг технологит хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулж, малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулан ажиллахыг Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (Ч.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга (Д.Гэрэлмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА        Д.МӨНХ-ОД

010000111